



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/172

Мандалговь

Г Дотоодын үйлдвэрийг дэмжих тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 2.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.1, Аймгийн Засаг даргын 2017 оны 01 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төсөвт байгууллагуудын хэрэгцээт бүтээгдэхүүний судалгаа, нэр төрөл, тоо хэмжээг нарийвчлан тодорхойлж, аймаг, сумын дотоодын үйлдвэрлэлээр хангах бүтээгдэхүүний жагсаалтыг 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан тусгайлан баталж 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн төсөвт байгууллагын хэрэгцээг аймаг орон нутгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Хоёр. Аймаг, сум орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын хүчин чадлыг тодорхойлуулан сум болон аймгаас хангагдах боломжтой бүтээгдэхүүнийг хангуулах талаар тэдэнтэй хамтран тохиролцож тодорхой үр дүнд хүрч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Өөрийн байгууллагын тухайн жилийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг аймгийн үйлдвэрлэлээс ханган, аймаг орон нутгийнхаа үйлдвэрлэл эрхлэгчид, баялаг бүтээгчдийг дэмжин ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, захирал нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Салбарын болон сумын хэрэгцээт бараа бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлээс хангагдсан тухай хангалтын дүн мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор авч дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс / Н.Эрдэнэ-Очир/, Нийгмийн бодлогын хэлтэс /Ц.Эрдэнэсүрэн/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, дүн мэдээг улирал бүрийн сүүлийн 25-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлд хэлэлцүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс / Н.Эрдэнэ-Очир/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



023000510